

АБТС | ХҮНД ХҮРСЭН
ББСБ | САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН



2023

АГУУЛГА

Танилцуулга

Бизнесийн үйл ажиллагаа

- Бизнесийн зорилго, зээлийн үйлчилгээ
- Зах зээлийн мэдээллүүд
- Санхүүгийн үйл ажиллагаа

Нийгмийн хариуцлага, Байгаль орчны нөлөөлөл

ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, компанийн засаглал

- ТУЗ-ийн бүтэц, үйл ажиллагаа
- Засаглалын кодекс
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлага түүний гүйцэтгэлийн шалгуур
- Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах стратеги

Санхүүгийн тайлан, тодруулга

- Санхүүгийн тайлан
- Нэмэлт тодруулга
- Хөндлөнгийн аудитын дүгнэлт

Mission**Эрхэм зорилго**

"Өөрийн болон хайртай хүмүүсийнхээ амьдралыг сайжруулах чин эрмэлзэлтэй хувь хүмүүст санхүүгийн дэмжлэг, эх үүсвэрээр хангах нь бидний эрхэм зорилго юм.

Vision**Алсын хараа**

Зорьсон зорилго, мөрөөдөлдөө хүрэхээр хичээнгүйлэн зүтгэж буй хүмүүст санхүүгийн тусламж үзүүлэх. Хүн өөрөө өөрийнхөө амьдралыг сайжруулахад бодит тусламж, зөвлөгөө өгөх.

Values**Үнэт зүйлс**

Бидний үнэт зүйл бол хүмүүстэй хамтран ажиллахын зэрэгцээ тэдний амьдралыг сайжруулахад нь туслах явдал юм. Үнэт зүйл маань бидний хамгийн том хөдөлгөгч хүч юм.

“АБТС ББСБ” ТАНИЛЦУУЛГА

Манай байгууллага 2001 онд үүсгэн байгуулагдаж өдгөө 22 дахь жилдээ харилцагчидийнхаа санхүүгийн хэрэгцээ шаардлагыг итгэл төгс ханган ажиллаж байна.

“АБТС” ББСБ нь үүсэн байгуулагдсан цагаасаа үйл ажиллагаандаа ил тод, нээлттэй зарчмыг баримтлан ажиллласаар ирлээ. Бизнесийн орчин, харилцагчийн эрэлт хэрэгцээ хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөө үед бид харилцагч бүрийн онцлог, хэрэгцээнд тулгуурласан санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд тасралтгүй нэвтрүүлж, дээд зэрэглэлийн тав тухтай орчинд, мэргэжлийн түвшний санхүүгийн найдвартай үйлчилгээг үзүүлэхээр ажиллаж байна.

ББСБ 2001 оны 10 дугаар сарын 4-нд Монголбанкнаас зээлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулж эхэлсэн билээ. “АБТС” ББСБ нь банкнаас санхүүгийн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал, орлого багатай иргэд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд эрэлт хэрэгцээнд нь нийцсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж, ажилгүйдлийг бууруулан тогтвортой амьжиргааг нь хангаж, улмаар Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Тодорхой зорилготой, тухайн зорилгодоо хүрэх чин эрмэлзэлтэй, хүчин зүтгэх, хөдөлмөрлөх хүсэлтэй хүн бүрт санхүүгийн туслалцаа үзүүлэн дэмжих нь бидний үйл ажиллагааны үндсэн зорилго юм. Бид санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, санхүүгийн үйлчилгээг дэвшилтэт мэдээлэл технологитой уялдуулан хөгжүүлэх, харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг олон улсын жишигт нийцүүлэн хангахын төлөө үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

2023 оны 10 сарын байдлаар “АБТС” ББСБ нь төслийн болон өөрийн эх үүсвэрээр давхардсан тоогоор нийт 3956 харилцагчдад 70.4 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. АБТС ББСБ өнөөдөр олон нийтэд танигдсан, найдвартай санхүүгийн зуучлагч болсон билээ. Манай чадварлаг боловсон хүчин, зохистой удирдлага, хувьцаа эзэмшигчдийн дэмжлэг, нэгдмэл сонирхолтой, тодорхой зорилгод чиглэсэн хамт олны маань хичээл зүтгэл, хөдөлмөр энэхүү амжилтын үндэс болж байгаа бөгөөд цаашдын амжилтад хүргэнэ гэдэгт итгэлтэй байна.

Бизнесийн зорилго

Манай банк бус санхүүгийн байгууллага дараах зорилго руу чиглэн ажиллаж байна.

- Банкнаас өөрт шаардлагатай санхүүгийн дэмжлэг авч чадахгүй байгаа иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн тусламж үзүүлэх.
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад жижиг, дунд бизнес эрхлэгчдэд туслах
- Шинэ үеийн шилдэг бичил санхүүгийн байгууллагуудын нэг болох.

Үйлчлүүлэгчид

Бид үйлчлүүлэгчдийнхээ үзэл бодолд ихээхэн анхаарал хандуулж, янз бүрийн хэрэгцээг нь хангахын тулд процедурыг хянан үзэх үйлчилгээ үзүүлдэг. Ийм байдлаар бид янз бүрийн нөхцөл байдал, хүндрэлтэй үед хүн бүрт туслах зорилготой маш уян хатан бодлогыг сурталчилдаг.

Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ

“АБТС” ББСБ өнөөдрийн байдлаар бизнесийн зээл, авто машины лизингийн зээл, хэрэглээний зээл, орон сууцны зээл, хашаа байшин худалдаж авах, засвар хийх зээл, цалингийн зээл зэрэг нийт 22 төрлийн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн боломжит хугацаагаар иргэд, ААНд санал болгож байна. Зээлийн бүтээгдэхүүний онцлог болон хугацаанаас нь хамааран зээлийн сарын хүү 0.7%-3.2% хувийн хооронд хэлбэлзэж байна.

Зээлийн бүтээгдэхүүний төрөл

- Барилгын зээл /төгрөг, валют/
- Хүнсний ногооны зээл
- Зоорь агуулахын зээл
- Тээвэр логистикийн зээл
- Худалдааны зээл
- Гар урлалын зээл
- Жижиг үйлдвэрлэлийн зээлийн шугам /төгрөг, валют/
- Орон сууцны зээл
- Орон сууцны нөхцөл сайжруулах зээл
- Хашаа байшин худалдан авах зээл
- Гэр хорооллын нөхцөл сайжруулах зээл
- Автомашины лизингийн зээл
- Хэрэглээний зээл

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛҮҮД

Монголын макроэдийн засгийн үзүүлэлтүүд

Монголын эдийн засагт 2023-2024 он нь уул уурхайн бүтээглэхүүний экспорт, гадаадын хөрөнгө оруулалт, хувийн байгууллагын зээл зэргээс ихээхэн хамааралтай жил байлаа.

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн бүтээгдэхүүний гадаад зах зээл дэх үнийн өсөлт, Засгийн газраас экспортод чиглэсэн зарим арга хэмжээний үр дүнд ДНБ 2023 онд 68.9 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.3 хувиар өссөн байна. Монголын эдийн засгийн өсөлт 2024 онд 8.1 хувийн өсөлттэй байх хүлээлттэй байгаа.

2022 онд эхэлсэн Орос, Украины дайны улмаас нефтийн бүтээгдэхүүний үнэ өссөн, БНХАУ-ын бодлоготой холбоотой тээвэр, ложистикийн үнэ нэмэгдсэнээр манай улсад инфляци нэмэгдсэн. 2023 оны гуравдугаар улирлын байдлаар Монгол Улсын инфляци 7.9 хувьд хүрч, оны эцэс гэхэд бага зэрэг буурах төлөвтэй байна.

2023 онд түүхий эдийн гол худалдан авагч болох Хятад улс ковидын тахлын үед хэрэгжүүлсэн тэг ковид бодлогыг цуцалснаар нүүрсний худалдан авалт эрчимжсэн жил байлаа. Энэ онд Монгол Улсын экспорт 15.1 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 5.98 тэрбум ам.долларын ашигтай ажиллаж, гадаад худалдааны тэнцэл 2023 онд түүхэн дээд хэмжээнд хүрч, гадаад валютын нөөц 4.98 тэрбум ам.долларт хүрсэн.


Монгол Улсын төсвийн 2023 оны тэнцэл сүүлийн таван жилд анх удаа 163.4 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Нөгөөтэйгөөр, экспортын бүтээгдэхүүн нэмэгдсэн нь валютын орох урсгалд нөлөөлсөн. Мөн шатахуун, шатахууны төрлийн бүтээгдэхүүний импорттой холбоотой валютын гадагшлах урсгал нэмэгдсэн нь валютын нийлүүлэлтийн өсөлтийг бий болгосон.

2023 оны эхэнд, 1 ам.доллар 3494 төгрөгтэй тэнцэж байсан бол 2023 оны төгсгөлд төгрөгийн ханш ам.доллартай харьцах харьцаа чангарч 2.5 хувиар өсөж 3410 төгрөг болсон. Мөн гадаад валютын албан нөөц 4.9 тэрбум ам.долларт хүрсэн.

Монгол банк 2022 онд бодлогын хүүтэй холбоотой нийт 6 шийдвэр гаргаж, оны эхэнд зургаан хувьтай байсан бодлогын хүүг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 13 хувь болгон шинэчлэн баталсан.

Өөрчлөлт орсон өдөр, хувь



Бодлогын хүүгийн тогтворгүй байдал нь санхүүгийн салбарт нөлөөлж, бизнесийн бүхий л салбарын зээл багасч, эсрэгээрээ цалин, тэтгэвэр, хадгаламжийн барьцаатай зээл зэрэг хэрэглээний зээл нэмэгдсэн.

Бизнесийн салбарын санхүүжилт буурч, өртөг нэмэгдсэн нь салбаруудын сэргэлтэд болон, зээлийн чанарт нөлөөлсөн. 2023 оны гуравдугаар улирлын байдлаар банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ 10.3 хувьд хүрсэн.

Хэрэглээний чанаргүй зээл өмнөх жилүүдтэй харьцуулахад хэвийн түвшинд байгаа бол уул уурхай, барилга, үйлчилгээ, худалдаа зэрэг бизнесийн салбарын чанаргүй зээлийн хэмжээ өссөн байна.

Санхүүгийн салбарын хөрөнгийн бүтцэд 73.7 хувийг банкны салбар, 17.8 хувийг хөрөнгийн зах зээл, 7.1 хувийг ББСБ-ын салбар, 0.9 хувийг даатгалын салбар, үлдсэн 0.5 хувийг хадгаламж зээлийн хоршоодын салбар бүрдүүлж байна.

АБТС-ийн үйл ажиллагаа явуулдаг банк бус салбарын хувьд нийт санхүүгийн салбарт эзлэх хувь 7.1 хувьтай байгаа бөгөөд сүүлийн 4 жилд дунджаар 32.5 хувийн өсөлттэй байгаа хамгийн хурдацтай хөгжиж буй салбаруудын нэг юм.

Салбарын үзүүлэлт

2023 оны байдлаар тус салбарт нийт 529 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт харилцагчдын тоо 4.56 сая болж нэмэгджээ.

2016-2023 онд ББСБ-ын нийт хөрөнгийн хэмжээ 1.1 их наяд төгрөгөөр нэмэгдэж 4.7 их наяд төгрөгт хүрч, жилийн дундаж өсөлт 32.5 хувьтай байна. 2023 оны дөрөвдүгээр улиралд ББСБ-ын нийт хөрөнгийн хэмжээ 4.7 их наяд төгрөгт хүрч, үүний 74.4 хувийг зээл, 14 хувийг бэлэн мөнгө, 11.6 хувийг бусад хөрөнгө эзэлж байна.

Ковид-19-ийн тархалтын жилүүдэд буюу 2019, 2020 онуудад зээлийн нийт хэмжээ 1.2 их наяд, чанаргүй зээлийн хэмжээ 10 орчим хувийг эзэлжээ. Гэвч Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсад олгосон зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах шийдвэр гаргаснаар чанаргүй зээлийн хэмжээ жил ирэх тусам буурчээ.

2021 оны хагасаас эхлэн хэрэглээний зээлийн эрэлт эрс нэмэгдэж, ББСБ-ын зээлийн багцын нийт хэмжээ 2021 онд 2 их наяд, 2022 онд 2,7 их наяд болж өсч, 2023 онд 4,7 их наяд болсон бол чанаргүй зээлийн хэмжээ дунджаар долоон хувьд хүрсэн байна.



САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“АБТС” ББСБ нь үүсгэн байгуулагдсан 2001 оны эцэстэй харьцуулахад 2023 онд нийт актив 224 дахин, нийт зээл 171 дахин нэмэгдсэн бөгөөд өөрийн хөрөнгө 142.5 дахин өсчээ. Өнгөрсөн оны эцсээс нийт актив 3,9%, өөрийн хөрөнгийн хэмжээ 4%-иар тус тус өссөн байна. 2023 оны байдлаар чанаргүй зээлийн хэмжээ 25%-иар буурсан нь өнгөрсөн онд Ковид цар тахлийн улмаас иргэд, ААН-н санхүүгийн чадварт үзүүлсэн хохиролын нөлөөлөл багасч мөн АБТС ББСБ нь бодлогын хувьд ч зээлийн багцын хэмжээнээс илүү түүний чанарт анхаарах болсонтой холбоотой юм.

АБТС ББСБ нь 19,806,119,659 төгрөгийн хөрөнгөтэй, 11,418,393,109 төгрөгийн зээлийн багцтай байгаагаас чанаргүй зээлийн багц 183 031 563 төгрөг байна.

График 1. Нийт зээл, нийт хөрөнгө (сая.төгрөг)




График 2. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон өөрийн хөрөнгө нийт активын харьцаа 20%-иас доошгүй байх шаардлага тавьдаг бол 2023 онд манай байгууллагын зохист харьцаа 27.03% байна.

График 3. Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгө (сая. төгрөг)




График 4. Зээлдэгчийн төрлөөр




График 4.2. Насны ангилал

График 4.1. Хувь хүн, Компани





График 4.3. Хүйсийн харьцаа



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ

Компанийн ажилтнуудын санаачлагаар цусаа хандивлав.



Хүний амь насыг аврах цус, цусан бүтээгдэхүүн нь үйлдвэрлэгдэх боломжгүй, эрүүл мэндийн амин чухал бүтээгдэхүүн бөгөөд насанд хүрсэн эрүүл хүн нэг удаа 400-450 мл цус хандивласнаар гурван хүний амь насыг аврах боломжтой байдаг.

Манай байгууллагаас хүндэт донор төрөн гарсан байдаг.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй мод тарих хөдөлгөөнийг дэмжин мод тарих, түүнийгээ хамгаалан ургуулах аянд оролцлоо.



THE
SOLUTION
IS LESS
POLLUTION

Нэг ширхэг мод дунджаар гурван хүн амьсгалах хэмжээний хүчилтөрөгчийг агаарт ялгаруулдаг ч эсрэгээрээ хаягдал болсон цаас ялзарч, өвчин үүсгэгч нянг үржүүлдэг бөгөөд нүүрсхүчлийн хийнээс 23 дахин хүчтэй хорт хийг агаарт ялгаруулдаг нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг.

Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах зорилгын хүрээнд бид цаасны хэрэглээгээ боломжит хамгийн бага хэмжээнд байхаар зохицуулан ажиллаж байна. Үүнд:

Зээлийн судалгаанд шаардагдах зарим материалыг заавал цаасан хэлбэрээр бус цахим платформуудыг ашиглан харилцагчдаас авч байна. Мөн ашиглагдсан боловч дахин ашиглах боломжтой цаасан материалыг дахин ашигласнаар цаасан хаягдлыг тодорхой хэмжээгээр бууруулах боломжийг олгодог

Цаасан хэлбэрээс цахим хэлбэрт шилжсэнээр нь нэг харилцагчтай хийх уулзалтын хугацаа болон хэрэгцээгүй их хэмжээний цаасан хаягдал гарахаас маш сайн сэргийлж байна. Бид цаашид тус зорилтын хүрээнд цахимаар зээл судлах зээлийн апп-тай болох зэрэг байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулахаар хичээнгүйлэн ажиллаж байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

АБТС ББСБ нь 8 хувь нийлүүлэгчтэй хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болох 3 хүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр удирдуулан Гүйцэтгэх захирал, 5 гишүүн бүхий зээлийн хороо, 5 эдийн засагч, санхүүгийн 2 ажилтан, маркетингийн менежер зэрэг бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хуулийн зөвөлгөө болон аудитын үйлчилгээг Монгол өмгөөлөгч хуулийн фирм, Гэрэлт хөхийн тэнцвэр аудитын байгууллагуудаас аутсорсингийн үйлчилгээ авч ажиллаж байна.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: ТАМИР
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД: АШИДМӨНХ, ЧИМГЭЭ

ТУЗ	ТУЗ-ийн дарга	Хувьцаа	Хуралдааны ирц
	Тамир	8.96%	100%
	ТУЗ-ийн гишүүн		
	Чимгээ	27.54%	100%
	ТУЗ-ийн хараат бус гишүүн		
	Ашидмөнх	1.18%	100%

Бид Компанийн засаглалыг сайжруулах, засаглалын кодексд нийцүүлэх зорилгоор 2024 оноос ТУЗ-ийн гишүүдийн тоог 5 болгох, хараат бус гишүүдийн тоог 2 болгох зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд шинээр 3 хороо байгуулахаар төлөвлөж байна. Мөн урт хугацааны зорилтын хүрээнд ТУЗ-ийн эмэгтэй гишүүдийн тоог 50% хүргэх, дийлэнх гишүүдийг хараат бус гишүүн байх зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна.



Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур

Тэнцвэржүүлсэн онооны систем буюу KPI дэх зорилтуудын биелэлтээр Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин болон бусад урамшууллыг олгодог. Үнэлгээг нийт 100 онооноос үнэлэх ба нийт 5 үзүүлэлтээр үнэлдэг. Үүнд

Дараах 5 үндсэн бүлэг үзүүлэлтүүдийг багтаана.



Гүйцэтгэлийн үнэлгээний биелэлтээр

Гүйцэтгэл маш сайн, зорилтыг давуулан биелүүлсэн

(ГНХ>90%)

Гүйцэтгэл хангалттай, зорилтыг бүрэн биелүүлсэн

(ГНХ>80%)

Гүйцэтгэл дунд, зорилтын ихэнх хэсгийг биелүүлсэн

(ГНХ>70%)

Гүйцэтгэл сул, зорилтыг хэсэгчлэн биелүүлсэн

(ГНХ>60%)

Гүйцэтгэл хангалтгүй, зорилтыг огт биелүүлээгүй

(ГНХ=<60%)

КОМПАНИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ

Оролцогч талууд

- Хувьцаа эзэмшигчид
- Ажилтан
- Хэрэглэгч, харилцагч
- Харилцагч байгууллага
- Төрийн байгууллага

2023 онд дээрх оролцогч талуудтай харилцан, хамтран ажилласан ажиллагааг хуульд заасан эрх зүйн хэм хэмжээг болон, ёс зүйн хэм хэмжээг баримталж ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийг мэдээ мэдээллээр хангах, хууль тогтоомжид заасан эрхийг хүндэтгэн тэгш хандаж шаардлагатай мэдээ мэдээллээр тухай бүрт нь хангаж, санал хүсэлтийг цахим шуудан, веб хуудас зэргээр идэвхитэй хамтран ажиллаж байна. Хуульд заасан хугацаанд хурлыг амжилттай зохион байгуулж хамтран ажиллаа.

Ажилтан нь үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гэдэг утгаар нь харилцахдаа хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хүрээнд харилцаж ажиллаж байна.

Хэрэглэгч, харилцагчийг компанийн орлогыг бүрдүүлэгч гэсэн утгаар нь тэдний хэрэгцээ чанар, тоон үзүүлэлтээр бүрэн хангах зорилго бүхий байгууллагын соёлыг бүрдүүлж харилцагчдад шаардлагатай мэдээ мэдээлэл, зөвлөгөөгөөр хангаж санал хүсэлтийг тухай бүрт нь шийдвэрлэн ажиллаж байна.

Харилцагч байгууллага компанийн үйл ажиллагааны эх үүсвэрээр хангагч гэсэн утгаар нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна. Талуудын хууль, гэрээгээр хүлээсэн эрх үүрэг, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн харилцагч байгууллагатай байнгын уялдаа холбоотой байдаг.

Холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг бүрэн хангаж, зохицуулагч, төрийн байгууллагад тайлан мэдээг цаг тухайд нь хүргүүлэхээр хичээнгүйлэн ажиллаж байна.

**“ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ” ХХК****“АБТС ББСБ” ХХК-ИЙН
УДИРДЛАГА ТАНАА**

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянгол дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө,
МҮЭ-ийн Соёлын төв ордон, 213 тоот
E-mail: info@ghtaudit.mn, Утас: 93099119

2024.03.01 № 24/53

танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид “АБТС ББСБ” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “АБТС ББСБ” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулагдсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг ирүүлсэн баримт материалын хүрээнд Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба НБЁЗОУСЗ-ийн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан

эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

“АБТС ББСБ” ХХК нь санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг.

Бид бусад асуудлуудын дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үзэж аудиторын тайландаа дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон тодорхойлдог.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Д.БААТАРСАЙХАН

Огноо:

АБТС ББСБ" ХХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант үе

	/Төгрөг/	
1. ХӨРӨНГӨ	2022.12.31	2023.12.31
1.1. Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	507,705,872.00	1,041,774,949.98
Дансны авлага	17,691,130,252.03	15,845,221,470.84
Татвар, НДШ-ийн авлага		
Бусад авлага	12,046,915.00	706,819,435.52
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал		
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
Бусад эргэлтийн хөрөнгө	979,353,028.99	734,048,839.50
Борлуулах зорилгоор эзэмшиж буй ЭБХөрөнгө		
Богино хугацаат хөрөнгө оруулалт		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,190,236,068.02	18,327,864,695.84
1.2. Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,419,714,146.76	1,476,338,532.68
Биет бус хөрөнгө	2,381,597.16	1,916,431.20
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээнийхөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,422,095,743.92	1,478,254,963.88
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,612,331,811.94	19,806,119,659.72
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
2.1. Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг		
Цалингийн өглөг		
Татварын өр		
НДШ-ийн өглөг		
Богино хугацаат зээл	1,050,000,000.00	2,350,000,000.00
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого		
Нөөц /өр төлбөр/		
Бусад БХӨТ	4,973,413,299.78	4,364,410,210.84
Борлуулах зорилгоор эзэмшиж буй ЭБХ-нд хамаарах ӨТ		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,023,413,299.78	6,714,410,210.84
2.2. Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	8,892,743,791.28	7,150,050,000.00
Нөөц /өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр		
Урт хугацаат түрээсийн өглөг		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	8,892,743,791.28	7,150,050,000.00
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	14,916,157,091.06	13,864,460,210.84
2.3. Эздийн өмч		
Энгийн хувьцаа	4,689,480,000.00	4,689,480,000.00
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал	679,074,000.00	679,074,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	327,620,720.88	573,105,448.88
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,696,174,720.88	5,941,659,448.88
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,612,331,811.94	19,806,119,659.72


Аудитор, МНБ

"ТЭРЭЛТ ХӨХИЙН
ТЭНЦВЭР АУДИТ" ХХК

АБТС ББСБ" ХХК
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант үе

		/Төгрөг/
Үзүүлэлт	Лавлагаа	2023 оны 12 сарын 31
Борлуулалтын орлого		2,060,259,986.05
Борлуулалтын өртөг		15,996,884.00
Нийт ашиг (алдагдал)		2,044,263,102.05
Түрээсийн орлого		
Хүүний орлого		3,082,720.42
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		901,356,248.78
Борлуулалт маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал		1,717,299,072.18
Санхүүгийн зардал		48,265,150.37
Бусад зардал		910,472,705.75
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)		269,389,570.15
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		272,665,142.95
Орлогын татварын зардал		27,180,414.95
Татварын дараах ашиг (алдагдал)		245,484,728.00
Зогсоосон үйл ажиллагааны ТД ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		245,484,728.00
Бусад дэлгэрэнгүй орлого		-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн		245,484,728.00
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Аудитор, МНБ 

**"ГЭРЭЛТ ХӨХЛҮЙН
ТЭНЦЭЭР АУДИТ" ХХК**

АБТС ББСБ" ХХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант үе

/Төрөлөөр/

	Хөрөнгийн галад					Нийт дүн
	Хатгасны хувьцаа	Нэмж төлөгдсөн хувьцаа	дахин үнэлгээний нэмэгдэл	вэлөгдөн хөрвүүлэлт	Эзлийн өмчийн бусад хэсэг	
2022 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	4,689,480,000.00	679,074,000.00				327,620,720.88
НББ-ийн боллогын өөрчлөлтийн нөлөө, алдааны задрулга						-
Загруулсан үлдэгдэл	4,689,480,000.00	679,074,000.00	-	-	-	327,620,720.88
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						245,484,728.00
Бусад дэлгэрэнгүй орлого						-
Өмчид гарсан өөрчлөлт						-
Зарласан ногдол ашиг						-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	4,689,480,000.00	679,074,000.00	-	-	-	573,105,448.88
						5,941,659,448.88

Аудитор, МНБ *Боржигон*
 "ТӨРЛӨТ ХӨХИЙН ТЭГНЭВЭР АУДИТ" ХХК

АБТС ББСБ" ХХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлант үе

		/Төгрөгөөр/
ҮЗҮҮЛЭЛТ		Тайлант жилийн дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>		14,707,681,046.20
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		3,389,603,821.05
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нохвороос хүлээн авсан монго		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого		11,318,077,225.15
<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>		14,249,782,242.80
Ажиллагчдад төлсөн		109,721,493.88
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		31,070,654.36
Бараа материал худалдан авахад төлсөн		
Ашиглалтын зардалд төлсөн		
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн		
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага		14,108,990,094.56
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		457,898,803.40
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>		2,453,329.64
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		2,453,329.64
Хүлээн авсан ногдол ашиг		
<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>		-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусад олгосон зээл болон урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		2,453,329.64
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>		73,716,944.94
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Валютын ханшийн зөрүү		73,716,944.94
<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>		-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Валютын ханшийн зөрүү		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		73,716,944.94
Валютын ханшийн зөрүү		
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		534,069,077.98
Монго,түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		507,705,872.00
Монго,түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,041,774,949.98

0.00

Аудитор, МНБ
**"ГЭРЭЛТ ХӨХИЙ
 ТЭНЦВЭР АУДИТ" ХХК**

АБТС банк бус санхүүгийн байгууллага

№ 1301, Меру тауэр, Жамъян гүний гудамж 18/2

Сүхбаатар дүүрэг 1, Улаанбаатар – 14240

Утас: (976-11) 318-133

Цахим шуудан: info@abts.mn

Цахим хаяг: abts.mn